

6. ДЭЛХИЙН ФИЛОСОФИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛҮҮДЭЭС

Джон Дьюи. Ардчилал ба боловсрол. /1916 он/.

Бүлэг 1: Боловсрол амьдралын амин чухал хэрэглээ болох нь

Нэг. Бодисын солилцооны үр дүнд амьдрал шинэчлэгдэх нь. Аливаа амьд биет ба амьгүй зүйлсийн хоорондын хамгийн том ялгаа бол амьд биет үргэлж шинэчлэгдэж байдагт оршино. Хэрвээ чулууг юмаар цохих юм бол тэр эсэргүүцэл үзүүлэх болно. Хэрвээ гаднаас үйлчилж байгаа хүч нь чулууны эсэргүүцлийн хүчнээс бага бол чулуу ямар ч өөрчлөлтгүй үлддэг. Эсрэг тохиолдолд чулуу нь олон жижиг хэсэг болон бутарна. Чулуу хэзээ ч өөрийн эсрэг энэ үйлдэлд хариу үзүүлэх буюу энэ үйлдлийг өөртөө ашигтайгаар хэрэглэх гэж оролдохгүй. Харин аливаа амьд биет нь гаднын хүчний нөлөөнд амархан сүйдэж болох боловч гаднын хүчний энергийг өөрт ашигтайгаар хэрэглэхийг үргэлж оролддог. Хэрвээ ийм хариу үйлдэл үзүүлж чадахгүй бол амьд бие нь хэдийгээр олон хэсэгт бутран унахгүй ч (ядаж энэ нь дээд бие организмуудын хувьд үнэн), өөрийн амьд биет гэсэн утгаа алддаг.

Аливаа амьд биет амьд байгаа л бол эргэн тойрны энергийг өөртөө ашиглахыг зорьдог. Жишээ нь, тэд гэрэл, ус чийг, хөрсийг ашигладаг. Ингэхдээ тэдгээрийг өөрийн амьд мөн чанараа хадгалан үлдэхэд хэрэглэдэг. Жишээ нь, ургамал ургахдаа гадна орчны энергийг ашиглан биеийн хэсгүүдээ бүрдүүлдэг. «Удирдлага» гэсэн үгийг энэ тохиолдолд хэрэглэх юм бол энэ нь амьд биет өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн орчин тойрны энергийг ашиглаж чадахгүй бол гадны энергид залгиулна гэсэн үг юм. Амьдрал гэдэг бол хүрээлэн буй орчинд нөлөөлөх замаар өөрийгөө шинэчлэх үйл явц билээ.

Өндөр хөгжилтэй аливаа амьд биетийн хувьд энэ үйл явц нь төгсгөлгүй удаан үргэлжилж чадахгүй юм. Амьд биет амьдралд бууж өгөх юм бол үхдэг. Ямар ч амьтан эцэс төгсгөлгүй удаанаар өөрийгөө шинэчлэн байж чадахгүй. Амьдралын үйл явц хэрхэн үргэлжлэх нь аливаа тодорхой нэгэн бие махбодиос хамаарахгүй. Амьд биетүүдийн шинэ төрлүүд шил шилээ даран бий болсоор байдаг. Дэлхийн шим ертөнцийн түүхээс харахад хэдийгээр ганц нэгэн зүйлийн амьтад төдийгүй бүхэл бүтэн амьтдын аймаг бүхлээрээ сүйрэн үгүй болох тохиолдол олон гардаг байсан ч, үүнийг амьдралын илүү баян төгс төрөл зүйлүүд залгамжилдаг байжээ. Зарим төрөл зүйлүүд мөхөн үгүй болоход түүний оронд мөхөөгч хүчин зүйлд илүү сайн зохицсон төрлүүд бий болдог байжээ. Мөнх үргэлжлэх амьдрал гэдэг нь амьд биетүүд хүрээлэн байгаа орчинтойгоо дасан зохицох үргэлжилсэн тэмцлийг хэлнэ.

Бид хэдийгээр «амьдрал» гэхээр ямар нэг амьд зүйл буюу энэ үгийн хамгийн анхдагч утгыг төсөөлдөг. Харин «амьдрал» гэдэг үгийг хэрэглэхдээ хувь хүний болоод нийгмийн өргөн хүрээтэй багц туршлагыг төлөөлүүлдэг. Жишээ нь, бид «Линкольны амьдрал» гэдэг номыг харвал энэ номонд зөвхөн тухайн хүний бие махбодын тухай өгүүлсэн байна гэж боддоггүй. Харин ч, гэр бүлийн байдал, эцэг эхийн нь хийдэг байсан ажил, энэ хүний зан араншин төлөвшихөд нөлөөлсөн гол үйл явдлууд; амьдралдаа олсон гол ололт амжилтууд; хүсэл эрмэлзэл, дуртай дургүй зүйлс, зовлон жаргал гээд амьдрал ахуйнх нь тухай бүрэн багц мэдээлэл өгөгддөг. Яг ийм байдлаар бид ямар нэг зэрлэг овог аймгийн тухай, эртний Афинчуудын тухай, орчин үеийн Америкчуудын тухай өгүүлдэг. «Амьдрал» гэдэг энэ үгэнд, тэгэхлээр, зан заншил, итгэл үнэмшил, гэр бүл, ялалт ба ялагдал, ажил амралт гээд олон ухагдахуун хамрагдан орсон байдаг.

Бид «туршлага» гэдэг үгийг ч яг ийм давхар утгаар нь хэрэглэдэг. Амьдралын тухай цэвэр физиологийн үүднээс ярих юм бол энэ нь амьдралын процессыг шинэчлэлийн замаар үргэлжлүүлэхийг хэлдэг. Амьд биетийн шинэчлэл нь хүн төрөлхтний хувьд бас шашин шүтлэг, ёс зүй, итгэл найдвар, баяр гуниг, ололт туршлага гээд нийгмийн олон талт асуудлууд үргэлжлэхийг бас хэлдэг. Нийгмийн амьдралын аливаа бүлэг шинэчлэгдсэн ч тэдний олж авсан туршлага нь үргэлжлэн хадгалагддаг нь бодит зүйл юм. Тэгэхлээр, боловсрол гэдэг бол амьдралын нийгмийн талын үргэлжлэл гэж үзэж болох юм. Аливаа нийгмийн анги бүлэглэлд багтан орсон ямарч хүн, орчин үеийн хотод төрсөн буюу зэрлэг овог аймагт төрснөөсөө үл хамааран эхээс төрөхдөө ямарч хэл яриа мэдэхгүй, нийгмийн үзэл бодолгүй, итгэл үнэмшилгүй, сул дорой амьтан байдаг. Нийгмийн аливаа анги давхаргын хүн цаг нь ирэхэд үгүй болох нь гарцаагүй. Гэлээ ч энэ нь тухайн бүлгийн амьдрал үргэлжлэхэд саад болохгүй.

Аливаа анги давхаргыг бүрдүүлэгч гишүүдийн үхэж төрөх хорвоогийн жам нь боловсролыг зайлшгүй хэрэгцээтэй болгодог. Нэг талаас, тухайн ангийн саяхан төрсөн гишүүд буюу энэ бүлгийн ирээдүйг тодорхойлох хүмүүс, нөгөө талаас нэгэнт хэрэгтэй туршлага мэдлэгийг эзэмшсэн насанд хүрсэн гишүүдийн хооронд эрс ялгаа байна. Нөгөө талаас саяхан төрсөн гишүүд нь зөвхөн амьд оршихуйн хувьд хадгалагдан үлдэх төдийгүй бас өөрийн бүлгийнхээ ашиг сонирхол, зорилго, мэдээлэл, ур чадвар, туршлагыг эзэмшсэн байх зайлшгүй хэрэгцээтэй бөгөөд хэрвээ ингэхгүй бол тухайн бүлгийн амьдрал төгсгөл болох болно. Зэрлэг овог аймагт хүртэл насанд хүрсэн гишүүд нь насанд хүрээгүй хүүхдүүдийг бодвол асар их туршлага мэдлэг хуримтлуулсан байдаг бөгөөд насанд хүрээгүйчүүдийг зөнгөөр нь үлдээвэл тэд энэ түвшинд хэзээ ч хүрч чадахгүй юм. Соёл иргэншил хөгжихийн хэрээр нийгмийн анги давхаргын залуу гишүүдийн анхдагч чадамж ба насанд хүрсэн хүмүүсийн мэдлэг туршлага, чадварын хоорондын ялгаа улам ихэсдэг. Зүгээр нэг бие махбодийн хувьд өсч том болох, амьдралын хамгийн анхан шатны мэдлэг чадвар эзэмших нь тухайн бүлгийн амьдралыг үргэлжлүүлэхэд хангалтгүй. Энэ ялгааг арилгахад үнэн сэтгэлийн хүчин чармайлт шаардагдах болно. Дөнгөж төрсөн хүмүүн нь тухайн нийгмийн давхаргын зорилго ба мөн чанарыг үл ойлгосон байдаг төдийгүй бас үүнийг үл тоомсорлодог. Ганцхан боловсрол л энэ ялгааг арилгаж чадна.

Нийгэм нь яг биологийн амьдралын нэгэн адил холбоо харилцаанд тулгуурлан оршин тогтнодог. Энэ харилцаа холбооны ачаар хүмүүсийн ажил хийх, сэтгэн бодох, санал сэтгэгдлийн бүх л нарийн нандин зүйлс нь насанд хүрэгчдээс залуучуудад дамждаг. Нийгмийн идэвхтэй амьдралаас гарч байгаа бүлэг хүмүүсээс нийгмийн амьдралд дөнгөж хөл тавьж буй хүмүүст дамжуулан өгч буй энэхүү итгэл үнэмшил, найдвар, хүлээлт, ёс горим, санал сэтгэгдлийн дамжлагагүйгээр нийгмийн ямар ч амьдрал цаашид оршин тогтнож чадахгүй. Хэрвээ нийгмийг бүрдүүлж байгаа гишүүд нь мөнх амьдардаг байгаад залуу үеэ хүмүүжүүлдэг байсан бол энэ нь тухайн хүний хувийн сонирхол байх байсан. Харин ийм биш учраас энэ нь нийгмийн зайлшгүй хэрэгцээ юм.

Хэрвээ хар тахалд алив нэгэн нийгмийн бүлэг давхаргын бүх гишүүд бүгдээрээ сүйдэх юм бол энэ нийгмийн бүлгийн оршин тогтнол эцэс боллоо гэсэн үг юм. Хар тахал өвчин гарах юм бол нийгмийн аль ч гишүүн түүнд өртөн үхэж болох нь ойлгомжтой. Гэвч хүмүүсийн хоорондын нас сүүдрийн ялгаа, өөрөөр хэлбэл, зарим нэг нь үхэж байхад зарим нэг нь хорвоод мэндэлж байдаг онцлогоос хамаарч үзэл санааг бусдад дамжуулах замаар нийгмийн бие махбодыг хадгалж үлдэх буюу бүр шинэчлэх боломж гардаг. Гэхдээ энэ шинэчлэл нь өөрөө бий болдоггүй. Жинхэнэ, бүрэн хэмжээний мэдлэг дамжиж чадахгүй бол хамгийн соёлтой нийгмийн бүлэг ч хамгийн зэрлэг бүдүүлэг үе рүүгээ эргэн орж болох юм. Үнэндээ хүмүүний үр төл нь маш сул дорой байдаг

тул ахмад үеийнхний сургаал, дэмжлэггүй үлдэх юм бол амьдрах наад захын чадваргүй юм. Өөр бусад амьтны үр төлтэй харьцуулахад хүний хүүхэд нь амьдрах чадвар маш сул байдгийн жишээ нь, биеийн хүчний чадвараа ч залуу хүн ахмад хүний удирдлага дор олж авдаг явдал юм. Энэ нь технологи, урлаг, шинжлэх ухаан, ёс зүйн талаар хүн төрөлхтний олж авсан их ололт амжилтын өр төлөөс бололтой!

Хоёр. Боловсрол ба харилцаа. Нийгмийн амьдралыг зохих ёсоор нь үргэлжлүүлэхэд сургах ба суралцахын ач тус нь маш ойлгомжтой тул бид энэ сэдвээр ярилцахад бүхэнд илэрхий зүйлийг хэт нурушсан болох буйзаа. Гэхдээ энэ сэдвээр бид ярихдаа албан ёсны буюу хэт номчирхсон хүлээснээс ангид байх болно. Сургууль гэдэг бол боловсроогүй залуу хүмүүсийн сонирхол төлөвшилийг бий болгох харилцааны нэг хэрэгсэл; гэхдээ бусад арга хэрэгсэлтэй харьцуулбал харьцангуй өнгөцхөн хэрэгсэл юм. Сургалтын илүү тууштай хэлбэрийг давуу талыг бид ойлгосон цагт л жинхэнэ шинжлэх ухааны аргачлалыг зохих ёсоор нь хэрэглэж чадна.

Нийгэм нь зөвхөн харилцаа холбооны үр дүнд оршин тогтнох төдийгүй бас олон тооны холбоо, харилцааны дунд оршин тогтнодог. Англи хэлний common, community, communication (ерөнхий, олон нийт, харилцаа холбоо) гэсэн үгсийн хооронд зөвхөн хэл ярианы адил төстэй зүйл байхгүй. Хүмүүс нийтээрээ (community) амьдрахдаа өөр хоорондоо нийтлэг ерөнхий (common) зүйлс дээр тулгуурладаг; харилцааны (communication) тусламжтайгаар өөр хоорондоо нийтлэг байгаа зүйлсээ ухааран ойлгодог. Нийгэм судлаачдын адил сэтгэлгээ гэж нэрлэдэг эдгээр нийтлэг зүйлс нь адил зорилго, илгэл үнэмшил, тэмүүлэл, мэдлэг боловсрол болно. Харин ийм зүйлсийг тоосго шиг зөөж болохгүй, бин шиг хүмүүст хуваагаад өгч болохгүй. Хүмүүсийг адил зүйлд итгэдэг гэдгийг нь мэдүүлэх харилцаа холбоо нь хүмүүсийн нийтлэг горьдлого, хүсэлтийг хангаж, сэтгэл санааны болоод оюуны нийтлэг зүйлтэй болгох болно.

Бие хүмүүс нэг дор байснаараа нэгдмэл нийгэм болж чадахгүйтэй нэг адил хэн нэгэн хүн олон мянган бээр алс холд амьдарлаа гээд нийгмийн амьдралаас тусгаарлагддаггүй. Өөр хоорондоо хэдэн мянган бээрийн зайд орших хүмүүс ном, захиа ашиглан нэгэн дээвэр доор амьдардаг хүмүүсээс илүү оюун санааны хувьд нэгдмэл болж болдог. Заримдаа нэгэн ижил зорилгын төлөө ажиллаж амьдарч яваа хүмүүс ч гэсэн нэгэн цул болж чаддаггүй. Энэ нь ямар нэг машин механизмын араа шүд нь задарч салбал өөр хоорондоо дахин нийлэхгүйтэй адил юм. Харин эдгээр хүмүүс өөрсдийн нэгдмэл зорилгоо ухамсарлаж түүнийг биелүүлэхээр адил санал сэтгэгдэл гаргавал сая нэг оюун санааны хувьд нэгдмэл цул болж болох болно. Гэвч нэг зорилготой гэдгээ ухаарахын тулд хүмүүст харилцаа холбоо хэрэгтэй. Ядаж л нэг хүн нөгөөгийнхөө юу бодож байгааг мэдэж түүнд өөрийн саналыг нэмэрлэхэд гарцаагүй харилцаа холбоо хэрэгтэй. Ойлголцол заавал харилцааг шаардана.

Ингэхлээр бид бас хамгийн нэгдмэл цул нийгмийн бүлгийн дотор ч нийгмийн гэж нэрлэж болохооргүй харилцаа байдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Аль ч нийгмийн бүлэг давхаргын доторх харилцаа холбооны ихэнх нь машин доторх шиг тусгай төлөвлөгөөний дагуу хэрэгждэг. Хувь хүмүүс нөгөө хүндээ хандахдаа тэр хүний хувийн ашиг сонирхол, хүсэл зорилгыг үл хайхран зөвхөн өөрийн зорилгыг биелүүлэхээр хандах удаа олон байдаг. Энэ нь, албан тушаалын ялгаа, биеийн хүчний албадлага, ажил мэргэжлийн онцлог, санхүү эдийн засгийн нөлөөлөл зэргээр илэрдэг. Жишээлбэл, эцэг эх ба хүүхэд, багш ба сурагч, ажил олгогч ба ажилтан, эзэн захирагч ба захирагдагч нарын харьцаа нь тэдний хамтран хийж байгаа үйл ажил нь хичнээн ойр байгаагаас үл хамааран, нийгмийн дотно харьцааг үүсгэдэггүй харин нийгмийн анги давхарга, зэрэг

зиндааг л тодорхойлдог. Тушаал өгөх ба түүнийг даган мөрдөх нь үйл ажил ба үр дүнд нөлөөлөхөөс биш, нэгдмэл хүсэл тэмүүлэл, ашиг сонирхлын хүрээг үл үүсгэнэ.

Нийгмийн бүх амьдрал харилцаа холбоогоор дамждагтай адилаар бүх харилцаа холбоо (бүх жинхэнэ нийгмийн амьдрал) нь боловсрол мэдлэг олгодог. Харилцаа холбооны нөлөөнд орж байгаа бүх хүмүүс бас мэдлэг туршлагаа нэмэгдүүлэх болдог. Нэг нөгөөгийнхөө бодсон буюу мэдэрсэн зүйлийг харилцааны тусламжтайгаар ойлгосон цагаас аваад түүний мэдлэг бас л их бага хэмжээгээр нэмэгдэх болно. Харилцаанд орсон нэг ч хүний мэдлэг өөрчлөгдөхгүй үлдэж чадахгүй. Та хэн нэгэнд өөрийн бодол саналыг ойлгуулахын тулд харилцаа холбоонд хэн нэг хүнтэй орсон бол, ялангуяа таны ойлгуулах гэсэн санаа нилээн нарийн түвэгтэй бол та харилцаа холбоо гэдэг хичнээн чухал болохыг ойлгоно. Харилцаа холбоонд үг хэлээрээ зөв орж чадахгүй бол сармагчин адил дохио зангаа хэрэглэхээс өөр аргагүй. Олон нийтийн газар очоод хэн нэгний яриаг санаандгүй чагнахаас бусад тохиолдолд, хэн нэгэнтэй ярилцаж, харилцаа үүсгэнэ гэдэг нь зөвхөн өөрийн санааг тэр хүнд хэлэх биш бас энэ тухай түүний бодлыг сонсоно гэсэн үг юм. Иймд аливаа харилцаа холбоо нь гарцаагүй урлаг юм. Иймд нийгмийн чухал аливаа хаилцаа холбоо нь түүнд оролцож буй хүмүүсийн хувьд заавал мэдлэг олгох шинжтэй болохыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Харин нэг зүйлээ олон дахин давтан улиг болгосон үед харилцаа холбоо нь өөрийн мэдлэг олгох шинж чанараа алддаг.

Эцэст нь, дүгнэн хэлэхэд нийгмийн амьдрал өөрөө сургах ба сурах үйл явцыг шаарддаг төдийгүй бас хүмүүсийн нэг дор хамтран амьдарч байгаа нь өөрөө сургалтын агуулгатай байдаг. Энэ нь хүмүүсийн мэдлэг туршлагыг арвижуулж, баяжуулна; төсөөлөл сэтгэлийг урамшуулж, баяжуулна; хэлсэн ярьсан болгондоо хариуцлагатай байх ухамсрыг бий болгодог. Цор ганцаараа (оюун санааны ба бие сэтгэлийн хувьд) амьдарч байгаа хүнд өөрийн өнгөрсөн туршлагаа эрэгцүүлэн бодох шаардлага бага гардаг. Насанд хүрсэн ба хүрээгүй хүмүүсийн хоорондын мэдлэг туршлагын ялгаа нь залуу бага хүмүүсийг зааж сургах хэрэгцээнээс гадна бас энэхүү зааж байгаа зүйл нь хялбар ойлгогдох ухагдах хэлбэртэй болгох шаардлагыг бий болгодог.

Гурав. **Албан ёсны сургалтын байх ёстой газар.** Хүн бусадтайгаа хамтран амьдрах явцдаа зүгээр л хүлээн авдаг мэдлэг ба албан ёсоор түүнд заавал сургадаг мэдлэг туршлагын хооронд зааг ялгаа бий. Эхний тохиолдолд, мэдлэг олгох үйл явц нь тохиолдлоос тохиолдолд явагддаг, ийм замаар олгогдох мэдлэг нь чухал байдаг боловч энэ мэдлэгийг олж авахын тулд заавал тусгай байгууллага холбоо шаардагдахгүй. Эдийн засаг, дотоодын, улс төрийн, хуулийн, шашны гээд аливаа нийгмийн байгууллага, бүлгийн хэр зэрэг амьдрах чадвартайг мэдэхийн тулд тэдний өөрсдийн мэдлэг туршлагаа өргөжүүлэх, баяжуулах чадвар нь хэр зэрэг болохыг мэдэх хэрэгтэй. Харин ийм мэдлэг дамжуулах үйл явцын үр дүн нь анх ийм мэдлэг хуримтлуулах явцуу санаанаасаа хол давсан байдаг. Жишээ нь, шашны байгууллага нь өөрсдийн эрх нөлөөг хадгалж үлдэх, бусад үзэл сурталтай тэмцэл явуулах үүднээс шашны сургалтыг анх эхэлсэн байдаг бол гэр бүлийн амьдралд энэ нь тухайн гэр бүлийн цаашид оршин тогтнох үндсийг хангах үүднээс хийсэн байдаг. Мэдлэг олгох ийм тусгай байгууллагын ажлын үр дүн нь аажмаар ухамсарт амьдралын чанар, үргэлжлэх хугацаанд нөлөөлөхийн адилаар энэ хүчин зүйл нь тухайн байгууллагынхаа үйл ажиллагааг удирдан залах хүчин болдог. Өнөөгийн манай өндөр хөгжилтэй нийгэмд хүртэл хүмүүст мэдлэг олгох энэ байгууллагын бий болгосон үр дүнг бусад материаллаг баялагтай харьцуулахад харьцангуй багаар үнэлдэг.

Харин залуу хүмүүсийг сургах тал дээр энэхүү байгууллагын зайлшгүй хэрэгцээтэй нь шууд харагддаг. Харин сургалтын явцын бүх нарийн ширийн зүйлийг бодолцон үзвэл ийм сургалтын үйл явц нь насанд хүрсэн хүмүүст заадагтай харьцуулбал илүү нарийн түвэгтэй байдаг. Насанд хүрээгүй хүмүүсийг сургах хэрэгцээ нь маш ойлгомжтой; тэдний зан чанар, биеэ авч явах хэлбэрийг өөрчлөх шаардлага нь нэн яаралтай байдаг тул эдгээрийг анхаарахгүй орхиж болохгүй. Нэгэнт тэр залуу хүмүүсийг нэг дор байлган сургах хэрэгцээ байгаагаас хойш энэ ажлыг гүйцэтгэх байгууллага байх нь гарцаагүй. Хүн төрөлхтөн аливаа байгууллага, бүлгийн гол үнэ цэнэ нь хүнд хүрэх мэдлэг чадвар гэж ойлгохдоо үүнийг голдуу залуучуудад сургалт явуулж байхдаа ойлгосон юм.

Улмаар сургах зүйлс нь хичнээн олон тоотой, нарийн байх тусам илүү албан боловсрол буюу шууд сургуульд сургах замаар мэдлэг олгох хэрэгтэй гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Хөгжил дорой нийгэмд албан ёсоор заавал сургах хэрэгцээ бага байдаг. Зэрлэг бүдүүлэг овог аймгуудад хүүхдийг сургахдаа насанд хүрэгчдэд хэрэглэдэг тэр л арга механизмыг шууд хэрэглэдэг. Тэд сургалтын тусгай материал, хэрэгсэл, байгууллага байхгүй; харин хүүхдийг тодорхой насанд хүрмэгц нь эр хүн болгох ёслолын дараа нийгмийн бүрэн амьдралд шууд татан оролцуулдаг. Ингэхэд хүүхдүүд нь насанд хүрэгчдийнхээ ёс заншил, сүсэг бишрэлээс суралцаж, насанд хүрсэн хүмүүсийн юу хийж байгааг даган дууриах замаар мэдлэг чадвар эзэмшдэг. Заримдаа насанд хүрсэн хүний хажууд дагалдан сурагч байдлаар байж шууд сурдаг бол заримдаа өөрсдийн тоглоом наадамдаа насанд хүрэгчдийг дууриах замаар шууд бусаар суралцдаг. Зэрлэг хүмүүст сургалтанд зориулагдсан тусгай газар гэж байхгүй юм.

Харин соёл иргэншил хөгжихийн хэрээр залуу хүний боломж ба насанд хүрэгчдийн мэдлэгийн хооронд асар их ялгаа үүсдэг. Илүү хялбар мэргэжлийг эс тооцвол насанд хүрсэн хүний хажууд зүгээр дагалдан сурагч байдлаар юм сурах улам бүр түвэгтэй болдог. Бас насанд хүрэгчдийн хийж байгаа ажил өөр тусгай газарт явагддаг болон учрыг нь ойлгоход илүү түвэгтэй болох тул түүнийг тоглоомондоо даган дууриахад бас хэцүү болж ирдэг. Иймд насанд хүрэгчдийн ажлыг үр дүнтэй даган дууриаж сурахад зайлшгүй тусгай урьдчилсан сургалт хэрэгтэй болно. Ингээд үүнд зориулагдсан байгууллага буюу сургууль, сургалтад хэрэгтэй материал буюу сурах бичиг бий болов. Тусгай ямар нэг мэргэжил, мэдлэгийг заах тусгай бүлэг хүмүүс гарч ирэв.

Ийм албан ёсны сургалтгүйгээр аливаа нийгмийн бүлгийн мэдлэг чадварыг бүрэн хэмжээгээр нь залуучуудад дамжуулах аргагүй юм. Ном сурах бичиг ба мэдлэг олгох үсэг бий болмогц, заавал насанд хүрэгчдийн дэргэд ажлаа явуулж байхад нь байлцах шаардлагагүй боллоо.

Гэхдээ шууд бус боловсролоос албан ёсны боловсролын системд шилжихэд зарим бэрхшээл бий. Тоглоомоор буюу шууд насанд хүрэгчдийн ажлыг даган дууриах нь зарим талаар амин чухал байдаг. Албан ёсны боловсрол нь аливаа практикгүй бол амархан хэт хийсвэр, номчирхсон болдог. Харин хөгжлийн доод шатанд байгаа нийгмийн сургалт нь шууд практикт биелэгдэж харагддаг, тухайн хүнийхээ зан чанарт салшгүй хадагдаж, өдөр тутмын амьдралын шаардлагаар батлагдаж байдаг.

Илүү өндөр хөгжилтэй соёл иргэншилд сурах зүйлс нь үсэг тэмдэгтүүдэд хадгалагддаг. Энэ нь ойлгомжтой даган дууриах аргаас эрс өөр, нилээн техникийн буюу хийсвэр байдаг. Бодит байдлын дүр зургийг шууд зураглан авах нь ихэнхдээ хийсвэр хуурамч байдаг тул заавал практиктай холбох

шаардлагатай байдаг. Албан ёсны сургалтын материал нь зүгээр л сургуульд үздэг объект болж үлдээд амьдралаас тасрах аюул бий. Ингэвэл, нийгмийн ашиг сонирхол ч анхаарлын гадна үлдэх болно. Ингэхэд нийгмийн амьдралын бүтцэд шууд ордоггүй боловч, голдуу техникийн чанартай мэдээлэл нь сургалтын гол зүйл болж үлдэх нь мэдээж. Ингээд бид боловсролын тухай ойлголтыг бий болголоо: энэ нь заримдаа нийгмийн хэрэгцээг огоорч, амьдралаас тасарсан байдаг ч аль зүйлийн тухай мэдээллийг тусгай тэмдэгтүүдэд хадгалдаг, түүнээ алс зайд дамжуулдаг хэрэгсэл юм.

Үүнээс харахад боловсролын философийн хүнд асуудлын нэг нь албан бус ба албан ёсны боловсролын хооронд зохистой харьцааг барих явдал юм. Мэдээлэл ба техникийн чадварыг олж авах нь нийгмийн бүтцэд нөлөөлдөггүй; учир нь даган дууриах бүдүүлэг сургалт нь нарийн мэдлэг олгоход учир дутагдалтай бол албан ёсны сургалт нь амьдралаас хэт тасран явцуу мэргэжилтэн гаргах аюултай байдаг. Хүн тусгай сургалтын явцад олж мэдэх мэдлэг ба бусад хүмүүстэй харьцаад зүгээр аажмаар хуримтлуулдаг мэдлэг хоорондын зааг ялгааг арилгах нь аливаа тусгай сургуулилын зорилт болж байна.

Дүгнэлт. Амьдралын мөн чанар нь өөрөө өөрийгөө үргэлжлүүлэхэд оршино. Ийм үргэлжлэх үйл явц нь зөвхөн шинэчлэлтээр хийгдэх тул амьдрал гэдэг бол өөрөө өөрийгөө шинэчилдэг үйл явц юм. Хоол тэжээл ба нөхөн үржихүй нь биологийн амьдралд хэрэгтэйн адилаар боловсрол нь нийгмийн амьдралыг үргэлжлүүлэхэд хэрэгтэй. Боловсрол нь өөрийгөө харилцаа холбооны тусламжтайгаар дамжуулах аргаар оршин тогтнодог. Харилцаа нь туршлагаа бусадтай хуваалцах хэрэгсэл тул бүхэнд хүртээлтэй. Энэ нь түүнд оролцож байгаа бүх хүмүүсийн мэдлэгийг нэмэгдүүлдэг. Мэдлэгийг дамжуулах үйл явцын чухал болох нь залуу хүмүүст мэдлэг дамжуулах явцад илүү мэдэгддэг. Нийгмийн амьдралын бүх тал нь боловсрол мэдлэг олгоход чиглэгдсэн байдаг бол энэ үр нөлөө нь залуучуудад мэдлэг олгоход илүү тод харагддаг. Нийгэм илүү хөгжихийн хэрээр албан ёсны сургалтын хэрэгцээ нэмэгддэг. Албан ёсны сургалтаар заадаг зүйлсийн тоо хэмжээ нэмэгдэхийн хэрээр сургуульд зааж байгаа онолын мэдлэг практик амьдралаас тасран салах аюул бас нэмэгддэг. Энэ аюул нь одоо улам их болсон. Учир нь сүүлийн хэдэн зуун жилүүдэд мэдлэгийн хэмжээ асар ихээр нэмэгдсэн.

Орчуулсан Т.Нэмэхжаргал